



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/532

Есөнбулаг

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 39 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Нийгмийн эмзэг бүлгийн хоол тэжээлийн" судалгааны ажлыг гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2.Гэрээгээр хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах 19,900,000 (Арван есөн сая есөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний батлагдсан зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ